



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/607

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Засгийн газрын 2017 оны “Захиалагчийн дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, 2024 оны 10 сарын 23-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 02/3383 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Хөвсгөл/ УТ2401900387 төсөл, арга хэмжээ гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга

Ажлын хэсгийн гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
-Хүнс, хөдөө аж ахуйн бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн
-Аймгийн орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан, ахлах мэргэжилтэн
-Хүнс, хөдөө аж ахуйн газрын-Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны дарга
-Гүйцэтгэх захирал-Хөдөөгийн шийдэл ХХК
-Нягтлан бодогч-Хөдөөгийн шийдэл ХХК

Нарийн бичгийн дарга: ХХААГ-ын Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны мэргэжилтэн

2. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлэгч аж ахуй нэгжүүдийн гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, тоног төхөөрөмжийг, хүлээн авсан акт, тэмдэглэл баталгаажуулсан зураг, Орон нутгийн өмчийн газар барааг хүлээн авсан тодорхойлолт, хөрөнгө бүртгэсэн маягт зэрэг баримт бичгийн бүрдүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргад даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ